

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэл нь хөрш орон судлал, гуравдагч хөрш орон судлал болон бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын асуудлуудад төвлөрөн хөгжсөөр байна. Энэ онд тохиож буй хүрээлэнгийн 55 жилийн ойн хүрээнд эрдэмтэн судлаачдынхаа бүтээлийн үр дүнг танилцуулах чухал тавцан болсоор ирсэн “Олон улс судлал” сэтгүүлийн ээлжит 115 дахь дугаарыг уншигч таны гарг өргөн барьж байгаадаа баяртай байна.

Энэ дашрамд 45 жилийн түүхтэй “Олон судлал” сэтгүүлийнхээ түүхээс Та бүхэнд цухас өгүүлэхэд анх “Дорно дахины судлалын асуудал” нэртэйгээр 1978-1991 онд хэвлэгдэн гарч улс, нийгэмдээ танигдсан нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл нэгэнт болж чадсан байна. Гэвч ардчилал, зах зээлийн шилжилтийн он жилүүдэд манай хүрээлэн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын хувьд “Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн, “Зүүн хойд Ази судлалын төв” хэмээн тусдаа үйл ажиллагаа явуулдаг бие даасан эрдэм шинжилгээний байгууллагууд болоход “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүлийн суурин дээр 1991 оноос “Дорно, Өрнө”, 1992 оноос “Зүүн хойд Ази судлал” гэсэн

эрдэм шинжилгээний сэтгүүлийг 1999 он хүртэл тус хоёр байгууллагаас тус тусдаа хариуцан гаргаж байжээ. Харин 2000 оноос хүрээлэн эргэн нэгдэж, бүтэц, зохион байгуулалт, судалгааны ажлын цар хүрээ, чиглэл өргөжсөн тул зэрэгцээ хэвлэгдэж байсан хоёр сэтгүүлийг нэгтгэж “Олон улс судлал” нэрээр гаргах болсон түүхтэй юм.

Өдгөө “Олон улс судлал” сэтгүүл уламжлалт цаасан суурьтайгаар хэвлэгдэхийн зэрэгцээ тогтмол цахим хувилбараар уншигч олонд хүрдэг болов. Ингэснээр сэтгүүлийн хүртээмж сайжирч, цахим орчин дахь хандалтын үзүүлэлт эрс нэмэгдэн өгүүллээ нийтлүүлэх хүсэлтэй судлаачид болон өргөн олон уншигчдын анхаарал сонирхлыг улам ихээр татах болоод байна. Тухайлбал, манай сэтгүүлийн www.imori.ac.mn, www.mongoliajol.info/index.php/JIS цахим хуудаснаа буй нийт бүтээлийг зөвхөн 2023 онд 57 мянга гаруй удаа татан авч ашигласан тоон үзүүлэлт байна.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” эрдэм шинжилгээний сэтгүүл нь DOAJ - Directory of Open Access Journals-д бүртгүүлсэн тус хүрээлэнгийн 2 дахь сэтгүүл болсон амжилттай 2023 оныг үдэж байгааг эрхэм уншигчид та бүхэндээ дуулгахдаа таатай байна.¹

¹ DOAJ нь дэлхийн өнцөг булан бүрд гарч буй эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүлүүдийн (open access) -ийн албан ёсны бүртгэл бөгөөд чанартай агуулгуудыг нээлттэйгээр хүн бүрд хүргэх зорилготой олон улсын өргөн хүрээтэй санаачилга билээ. Одоогоор DOAJ бүртгэлд дэлхийн 133

2023 онд манай сэтгүүлийн редакц гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэлд хөндлөнгийн хянан магадалгааг тус бүр хоёр удаа хийж, долоон өгүүллийг сонгон авч хэвлэж байна. Тэдгээр өгүүлүүд БНХАУ-ын “Зөөлөн хүч”-ний бодлого, Монгол-Хятадын харилцаа, Монгол-Зөвлөлтийн харилцаа, Монгол-Орос-Хятад гурван улсын эдийн засгийн коридор, БНХАУ, БНСУ зэрэг улсуудын дотоод нөхцөл байдал болон, өөрчлөгдөж буй дэлхийн дэг журам дахь улс хоорондын харилцаанд сүүлийн арван жилд эрчтэй судлагдаж буй “Гибрид дайн”-ы асуудал зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хөнджээ.

Өнөө цагийн олон улсын харилцаанд өрнөж буй их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөнд уламжлалт хүч болоод хурдацтай хөгжиж буй мэдээллийн технологид суурилсан уламжлалт бус хүчний элементүүд ашиглагдах болж, Монгол Улсын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц гадаад орчны эрсдэлийг Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн багш, доктор Пүрэвдоржийн Мягмардорж “Орчин цагийн олон улсын харилцаа ба “Гибрид дайн”-ы талаар хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт” өгүүлэлдээ хэрхэн шинжилснийг бид энэ удаагийн дугаартаа онцолж байна.

Түүнчлэн, БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилгын 10 жилийн

ой тохиож буй энэ онд манай хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Максимын Хишигтуяа “БНХАУ-ын Зөөлөн хүчний бодлогын нөлөө ба Монгол Улс” өгүүллийг бичиж нийтлүүлж буйг мөн онцолж байна. Тэр бээр өгүүлэлдээ БНХАУ Хятадын соёлын зөөлөн хүчний бодлогын гол стратеги болох “Соёлын гадагш гарах” стратегийн хүрээнд хятад хэлний боловсрол, хэвлэл мэдээлэл, кино урлаг зэрэг салбарыг соёлын дипломат ажиллагааны арга хэрэгсэл болгон ашиглаж байгаа байдал ба Монгол Улс дахь хэрэгжилтийг авч үзжээ.

Мөн БНХАУ-ын бодлого тодорхойлогчдын авч хэрэгжүүлж буй шинэ алхмууд, тэдгээрийнх нь хэрэгжих боломж ба тулгарч болох гадаад, дотоод сорилтуудын талаар хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан Мөнхөөгийн Эрдэнэбаяр “Хятад маягийн модернизаци” хэмээх өгүүлэлдээ хэрхэн задлан шинжилсэнтэй та бүхэн танилцах боломжтой. Түүнчлэн БНХАУ-ын Фудань Их сургуультай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Сэлэнгэ нарын “Нэг бүс Нэг зам” санаачилга дахь байгаль орчны асуудал: Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридорын жишээн дээр” өгүүлэлд энэхүү санаачилгын дагуу хэрэгжүүлж

орны 19603 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэлтэй байна. Дашрамд сонирхуулахад DOAJ-д Монгол Улсаас өнөөгийн байдлаар 7 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэгдсэн байгаа бөгөөд үүнээс 6 нь #MongoliaJOL платформын эрдэм шинжилгээний сэтгүүлүүд байна. <https://doaj.org/toc/2663-7871>

буй дэд бүтцийн төслүүдийн хүрээлэн буй орчин, байгальд үзүүлэх нөлөө гурван улсын эдийн засгийн коридорын хамтын ажиллагааны жишээн дээр хэрхэн илэрч буйг шинжлэн судалсныг үзэж болно.

Тус хүрээлэнгийн Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Дашдаваагийн Мягмарын “БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд” өгүүлэл БНСУ-ын экспортыг дэмжих чиглэлд олсон амжилт, туршлагаас Монгол Улсад хэрэг болохуйц зарим жишээг тодруулах зорилгын хүрээнд бичигдсэн байна. БНСУ-ын улсын аж үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлсэн туршлага, бодлого хөтөлбөрүүдийг 1960-аад он, 2000 оноос хойших гэсэн хоёр үечлэлд тоймлон авч хэрэгжүүлсэн бодлого хөтөлбөрүүдээс манай улсад тусган авч болох жишээнүүдийг дурдсан нь тун сонирхолтой болжээ.

Дээрх өгүүлүүдээс гадна ХХ зууны үеийн Монгол Улс ба хөрш хоёр орны харилцааны талаар өгүүлүүд энэ дугаарт нийтлэгджээ. Тэдгээр нь академич Цэдэндамбын Батбаярын бичсэн “Монгол-Зөвлөлтийн харилцаа (1925-1928)”, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын захирал, доктор Намжилчойжилын Алтантөгсийн бичсэн “1954 оны Монгол-Хятадын ажиллах хүчний хэлэлцээр”-ийн хүрээнд Өвөр Монголоос ажилчин авах Монголын бодлого” хэмээх өгүүлүүд болно. Академич Ц.Батбаярын өгүүлэлд Зөвлөлтийн цэргийг Монголоос гаргах асуудал

тухайн үеийн Монгол-Хятадын харилцаанд хэрхэн нөлөөлсөн болон Монгол-Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн харилцаанд тулгарч байсан асуудлуудыг шинжилжээ. Харин доктор Н.Алтантөгс өгүүлэлдээ БНМАУ-ын бүтээн байгуулалтад ажиллах хүчнээр туслах тухай БНМАУ-БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 1955-1964 онд Монголд ирж ажилласан хятад ажилчдыг Хятадын талаас аль болох олон ажилчныг илүү урт хугацаагаар БНМАУ-д амьдрах эрхтэй үлдээхийг эрмэлзэж байсны учир шалтгааныг судлан тодруулахыг зорьсон байна.

Энэхүү дугаарт өгүүлээ нийтлүүлсэн эрдэмтэн судлаачид болон үнэт цаг заваа харамгүй зориулан бодит шүүмжийг ирүүлсэн нийт шинжээч эрдэмтэд, Редакцын зөвлөлийн гишүүд тэр дундаа сэтгэл гарган ажилласан сэтгүүлийн нарийн бичгийн дарга, магистр Болдын Хишигжаргалд Ерөнхий редакторын хувьд гүн талархал илэрхийлж байгаагаа үүгээр уламжилъя.

“Олон улс судлал” сэтгүүлийн 2024 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүлээ хэвлүүлэх хүсэлтэй эрдэмтэн судлаач Та бүхэн <https://mongoliajol.info/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээж болохын зэрэгцээ сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ mjis@mas.ac.mn цахим шуудангаар ирүүлбэл бид хэзээд талархан хүлээн авах болно.

Ерөнхий эрхлэгч